



Оюутан сонгон судлах хичээлээр гүйцэтгэсэн бие даалтын ажлын чанар, үр дүн

Даваажав Үнэнбаяр¹, Лэгдэн Туяа^{2*}, Цэрэн Эрдэнэжаргал³, Өлзий Ариунзул⁴
Монгол улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Сургуулийн өмнөх боловсролын сургууль,^{1,2} Арга зүйн тэнхим,
^{3,4} Урлагийн тэнхим
*Холбоо барих зохиогч: ayut_1@msue.edu.mn

Хүлээн авсан: 2020.10.27

Хянагдсан: 2021.05.11

Зөвшөөрсөн: 2021.06.13

Хураангуй

“Багш, сургуулийн өмнөх боловсрол” мэргэжлээр суралцагч нь дээд боловсролын бакалаврын түвшний сургалтын төлөвлөгөөнд тавигдах шаардлага, стандарттай нягт уялдан нийцсэн ерөнхий суурь, багш боловсролын суурь, мэргэжлийн заавал болон сонгон судлах хичээлүүдийг судлан бие даалтын ажлыг гүйцэтгэдэг. Оюутны бие даасан ажил нь тэдний хэрэгцээ, сонирхол, чадавх, ирээдүйн мэргэжлийн шаардлага зэргийг үндэслэн хичээлийн бус цагаар багшийн шууд бус удирдлага туслалцаа дор явагдаж буй суралцах, судлах, бүтээх үйл явц юм (Ичинхорлоо, 2011.х.99). Иймээс бид, мэргэжлийн арга зүйн хичээлтэй залгамж холбоотой төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжим, хүүхдийн хөдөлгөөн эрүүл мэнд, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүйн сонгон судлах хичээлүүдийн бие даалтын ажлыг нэгдмэл байдлаар зохион байгуулахад зарцуулах хугацаанд гарах өөрчлөлтийг судлах зорилго тавьсан. Судалгааг IV дамжааны оюутнуудын дунд зохион байгуулж, бие даалтын ажлыг гүйцэтгэхэд зарцуулсан хугацаа, багштайгаа эргэх холбоотой ажилласан байдлыг асуулгын аргаар судалсан. Фокус бүлгийн ярилцлагаар бие даалтын ажлыг нэгдмэл байдлаар гүйцэтгэсний ач холбогдлын талаар хэлэлцсэн. Гурван хичээлийн бие даалтын ажлын үнэлгээний дундаж үзүүлэлт 3.86%-ийн өсөлттэй байгааг хичээл хоорондын уялдаа холбоо нэг нь нөгөөгөөсөө хамаарч гүйцэтгэхэд хялбар байсантай холбож үзлээ. Оюутан өөрийн давуу тал дээр тулгуурлан бие даалтын ажлыг гүйцэтгэснээр бусад хичээлд өндөр үнэлгээг авч сэтгэл ханамжтай байхаас гадна цагаа нарийвчлан төлөвлөж чадсанаар даалгаврын чанарт ахиц гарсан.

Түлхүүр үг

Сонгон судлах, нэгдмэл сургалт, оюутны бүтээлч идэвх

Удиртгал

Монгол Улсын “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй багш ажиллана” (БСШУЯ, 2012, х.22) гэж заасан. Үүнтэй холбоотойгоор Засгийн

газрын 2014 оны 71-р тогтоолоор батлагдсан “Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл”-д сургуулийн өмнөх боловсролын багш мэргэжлийг оруулсан нь энэ мэргэжлийн хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны сайдын 2019 оны 07-р сарын 05-ны өдрийн №430 тоот тушаалаар “Хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт”-д цэцэрлэгийн багш нь хүүхэд бүртэй ажиллах, тэдний бүтээлч, идэвхтэй оролцоог хангах, бага насны хүүхдийг хөгжүүлэх, эрүүлжүүлж чийрэгжүүлэх, хүмүүжүүлэх ажлыг төлөвлөж, зохион байгуулж ажиллах ёстойг тусгасан байдаг. Цэцэрлэгийн багшийн ажлын байранд хүүхдийн цогц хөгжлийг дэмжихэд дуу хөгжим, хөгжимт хөдөлгөөн, бие бялдар хөгжүүлэх, эрүүл мэнд чийрэгжүүлэлт, дүрслэн урлахуйн ур чадварууд үргэлж шаардлагатай байдгийг үндэслэн багшийн ур чадварыг сайжруулах зорилгоор 2011 оноос эхлэн “МУБИС-ийн сургалтын журам”-ын 4.14.1 заалтыг үндэслэн (МУБИС, 2019, х.251) СӨБС-ийн захирлын 25 тоот тушаалаар ур чадварын төгсөлтийн шалгалтыг авч эхэлсэн. Уг шалгалтад Бие бялдар хөгжүүлэх арга зүй; Хөгжмийн боловсролын онол, арга зүй; Дүрслэн урлахуйн хөгжил, арга зүйн хичээлүүдийг нэгдмэл байдлаар зохион байгуулсан. 2018 оны А/322 тушаалын II хавсралт батлагдсаны дагуу өдрийн 4 жилийн ангид сонгон судлах хичээлийн стандарт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжим (ТХЦДХ); Хүүхдийн хөдөлгөөн, эрүүл мэнд (ХХЭМ); Цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүй (ЦСХБАЗ) сонгон судлах хичээлүүд нь дээрх арга зүйн хичээлтэй залгамж холбоотойгоор оюутны мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэн зохион байгуулах болсон.

Мэргэжлийн ур чадварын сонгон судлах хичээлүүдээр оюутан дараах чадваруудыг эзэмшдэг. Үүнд: 1) ТХЦДХ-ийн хичээлээр хөгжмийн онол арга зүйн мэдлэгт тулгуурлан, төгөлдөр хуур цахилгаан даралтат хөгжмөөр хүүхдийн болон зохиолын дуунуудыг тоглож дуулах, улмаар тохирсон аялгуунд аккордыг хувиргаж болох талаар практик дээр гүнзгийрүүлэн судалж, хөгжмийн үйл ажиллагааг зохион байгуулах чадвар, 2) ХХЭМ-ийн хичээлээр хүүхэд бүрийн онцлог, хөгжих хэрэгцээнд суурилсан эрүүл мэндийг дэмжиж, авьяасыг хөгжүүлэх, дугуйланг удирдах орчин үеийн дэвшилтэд аргад суралцан хэрэглээнд тулгуурласан практик дасгалжуулалтын аргыг эзэмшсэнээр бага насны хүүхдийн хөгжлийн ахицыг тогтоож, хөдөлгөөний чадвар дадлыг сайжруулах, дасгал хөдөлгөөнийг боловсруулах, удирдан зохион байгуулах чадвар, 3) ЦСХБАЗ-н хичээлээр орчин үеийн сургалтын шаардлагад нийцсэн хүүхдийн онцлог ялгаатай байдалд тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомыг хялбар технологи, дахин ашиглах материал хэрэглэн урлан бүтээх, оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх чадвар. Оюутны эдгээр чадваруудыг хөгжүүлэхэд бие даалтын ажлын хэлбэрийг өөрчлөн олон хувилбартай болгон турших хэрэгцээ байлаа. Бие даалтын ажлын агуулгын хүрээнд оюутан суралцсан зүйлээ амьдралд хэрэглэх чадвар дадал эзэмших зорилготой байдаг. Бид судалгааны ажилдаа бие даалтын ажлын төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмуудыг баримталсан. Үүнд:

- Бие даалтын ажлын зорилго тодорхой байх
- Судалж байгаа хичээлийн үндсэн агуулгатай холбоотой байх
- Бие даалтын ажил нь хичээлийн нэг долоо хоногийн цагийн ногдолд тавигдсан цагтай дүйцэх хэмжээний ачаалалтай байх (хэтрүүлсэн эсвэл дутаасан байх ёсгүй)
- Хичээл, сэдэв бүрээр ашиглах ном, сурах бичгийн нэр, бүлэг, хуудас, веб хаяг, хайлт хийх түлхүүр үгнүүд, ажлын хэмжээ, багшид дүгнүүлэх хугацаа,

харгалзах үнэлгээ буюу оноо зэрэг нь суралцагчдад ойлгомжтой, ил тод байх явдал хамгаас чухал байдаг (Бадарч, 2014, х.89).

“Сүүлийн үеийн оюутны бие даалтын ажлын философи үндэслэл нь прагматик үзэл, суралцагч төвтэй сургалтын концепц, конструктив хандлага, когнитив үзэл санаа зэрэг болно. Энэ нь юун түрүүнд оюутан өөрт хэрэгтэй мэдээллийг бие даан олж харах, түүнийгээ боловсруулах, амьдрал практик үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэглэх, асуудлыг бие даан олж харах, түүнийг шийдвэрлэхийн тулд өөрийгөө дайчлан бүтээлчээр эрэл хайгуул хийж ажиллах олон арга барилтай болно” (Ичинхорлоо, 2015, х.135). Мөн Батхуяг (2012, х.35) бүтээлдээ “...оюутны бие даалтын ажлыг нэгдмэл байдлаар төлөвлөж хийлгэх нь оюутанд болон багшид ажлын ачаалал, цаг хугацааны талаасаа ач холбогдолтой” гэжээ. Оюутан бие даалтын ажлыг гүйцэтгэх явцад тухайн хичээлээр судалж буй онолын ухагдахууныг бататгах, гүнзгийрүүлэн судлах, оновчтой шийдвэр гаргах, өөрийгөө дайчлах, бусадтай хамтрах, тасралтгүй хөгжихөд багштайгаа эргэх холбоотой ажиллах хэрэгцээ байдаг.

Эргэх холбоо нь багш зөвхөн мэдээлэл өгөх бус, сурагчдын бүтээлч байдлыг өдөөж, эрэл хайгуул хийх, асуудлаа шийдвэрлэхэд зөвлөн туслах хамтын үйл явц юм. Оюутан бие даалтын ажлын зорилгоо ухамсарлан багштай эргэх холбоотой ажилласнаар даалгаврыг бүтээлчээр гүйцэтгэх боломж нөхцөл бүрдэнэ (Henderson, M., Ajjawi, R., Boud, D., & Molloy, E. (Eds). 2019. х. 44).

Монгол улсын боловсролын их сургуулийн Сургуулийн өмнөх боловсролын сургууль нь “Багш, сургуулийн өмнөх боловсрол” мэргэжлээр, 124 кредит цагийг судлахаас 108 кредит буюу 87%-ийг заавал судлах, 16 кредит буюу 13% нь сонгон судлах хичээлийг судалж тухайн мэргэжлийг гүнзгийрүүлэн эзэмшдэг. Суралцагч хичээлийн стандартаар тодорхойлсон үр дүнд хүрэхийн тулд тэдний хийж гүйцэтгэх ажлыг оновчтой төлөвлөн хичээлийн үр дүн болон суралцахуйн үйл ажиллагаанд нийцсэн эсэх, бие даан судлах дасгал даалгавар, ажлууд нь хичээлийн кредитийн багтаамжид тохирсон эсэхийг тооцсон байдаг. Сонгон судлах хичээл нь суралцагчдын онцлог, хөгжлийн ялгаатай байдалд тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэй суурь мэдлэг эзэмшиж чадваржих, өөрийгөө байнга хөгжүүлэх, бүтээлч сэтгэлгээтэй багш мэргэжилтнийг бэлтгэхэд үр нөлөөтэй.

Сонгон судлах хичээлүүдийн бие даалтын ажлыг нэгдмэл байдлаар зохион байгуулахад оюутан цагийн менежментийг зөв хуваарилж бүтээлч идэвхийг нэмэгдүүлж үнэлгээнд гарах өөрчлөлтийг судлах зорилго дэвшүүлэн удирдамж боловсруулан туршилт судалгааг хийсэн. МУБИС-ийн СӨБС-ийн 4-р дамжааны Төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжим, Хүүхдийн хөдөлгөөн эрүүл мэнд, Цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүйн сонгон судлах 3 хичээлийг зэрэг сонгосон 19 оюутан туршилтын бүлэгт, дээрх хичээлийг харилцан адилгүй сонголт хийсэн 19 оюутан хяналтын бүлэгт хамрагдсан. Хугацааны хувьд 2018-2019 оны хичээлийн жилийн хаврын улиралд зохион байгуулсан.

Судалгааны арга зүй

Төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжим, хүүхдийн хөдөлгөөн эрүүл мэнд, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүйн сонгон судлах хичээлийн бие даалтыг нэгдмэл байдлаар гүйцэтгэх туршилтыг зохион байгуулна.

- Хүүхдийн дууг цахилгаан даралтат хөгжмөөр хөгжимдөж дуулна.
- Сэдвийн хүрээнд сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэнэ.
- Сонгосон дууны аялгуунд тохируулан өөрийн бэлтгэсэн хэрэглэгдэхүүнээ ашиглан, хөгжимт гимнастикийн дасгал, тоглоом зохиомжлон гүйцэтгэнэ.

Хичээл тус бүрээр бие даалтын ажлын гүйцэтгэл, зохиомж, өөрийгөө илэрхийлэх чадвар гэсэн 3 үзүүлэлтийг 25 онооны рубрикээр үнэлж дүгнэсэн болно. Бие даалтын ажлыг гүйцэтгэх хугацааг тооцох, багштай эргэх холбоотой ажилласныг асуулгын аргаар авч харьцуулж үр дүнг тооцсон. Фокус бүлгийн ярилцлагыг “Оюутан мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэхэд бие даалтын ажлын ач холбогдол” сэдвээр 12 оюутны дунд зохион байгуулсан.


Судалгааны үр дүн

Сонгон судлах төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжим; Хүүхдийн хөдөлгөөн, эрүүл мэнд; Цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүйн гурван хичээлийн хөтөлбөр стандартад нийт 6 бие даалтын ажлыг гүйцэтгэдэг бөгөөд үүнээс ганцаарчилсан хэлбэрээр 66%, хосоороо гүйцэтгэх 17%, багаар гүйцэтгэх 17% -тай байна. Эдгээрээс ганцаарчлан гүйцэтгэх бие даалтын ажил нь харьцангуй өндөр хувьтай байгааг үндэслэн бид судалгаандаа бие даалтыг ганцаарчлан гүйцэтгэх хэлбэрийг сонгон авч сургалтын нэгдмэл арга зүйг ашиглан цогц байдлаар гүйцэтгэсэн.

Туршилтын бүлгийн (ТБ) оюутан бие даалтын ажлыг гүйцэтгэхийн тулд сэдэв сонгож төлөвлөгөө боловсруулахдаа тухайн сэдвийн хүрээнд дуу сонгох, хичээлийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, эдгээрийг ашиглан дасгал тоглоомыг зохиомжилсон. Харин хяналтын бүлгийн (ХБ) оюутан хичээл тус бүрийн бие даалтыг удирдамжийн дагуу боловсруулсан болно. Судалгаанд оролцсон ТБ болон ХБ-ийн оюутнуудын бие даалтын ажлын үнэлгээг сонгон судлах хичээл тус бүрээр авч үзсэн.

График 1

Оюутны бие даалтын ажлын үнэлгээг хичээл тус бүрээр харьцуулсан байдал



Сонгон суралцах хичээл тус бүрийн бие даалтын ажлыг 25 оноогоор үнэлсэн. ТБ болон ХБ-ийн оюутны дундаж үнэлгээг харьцуулан үзэхэд цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүй 3%, төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжим 5.35%, хүүхдийн хөдөлгөөн эрүүл мэнд хичээлээр 3.25%-иар тус тус илүү үнэлгээ авч үнэлэгдсэн байна. Энэ нь ТБ-ийн оюутан өөрийн сонирхлын дагуу сэдвээ сонгон цогц байдлаар төлөвлөж, хичээл тус бүрийн онцлогийг харгалзан харилцан уялдаа холбоотой гүйцэтгэж чадсанаар өндөр үнэлэгдэж илүү үр дүнтэй байгааг харуулж байна. Бид оюутны үнэлгээг тооцож үзэхээс гадна тэдний сонгон судлах хичээлийн бие даалтад зарцуулж буй хугацааг асуулгын аргаар авч харьцууллаа.

График 2

Бие даалтыг гүйцэтгэхэд зарцуулсан хугацааг өдрөөр харьцуулсан үр дүн



Бие даалтын ажлыг гүйцэтгэсэн хугацааг өдрөөр тооцсон дундаж үзүүлэлтийг харьцуулахад ТБ нь ХБ-ээс 8.72%-иар бага үзүүлэлттэй, харин 4-5 өдөрт 4%-иар их, 7-10 өдөрт 5.24%-иар их хугацааг зарцуулсан байлаа. Үүнээс дүгнэхэд нэгдмэл байдлаар гүйцэтгэсэн оюутнууд цөөн өдөрт бие даалтын ажлыг сайн гүйцэтгэж байгааг харуулж байна. Судалгаандаа сонгоны бие даалтад зарцуулж буй хугацааг өдрөөс гадна цаг минутаар тооцон үзсэн.

График 3

Бие даалтын ажлыг гүйцэтгэхэд зарцуулсан хугацааг цаг минутаар харьцуулсан үр дүн



График 3-аас дүгнэхэд сонгон судлах хичээлийн бие даалтын ажилд 31-60 минут зарцуулсан ХБ-ийн оюутнууд 33.3% харин ТБ нь 35.1% үзүүлэлттэй байгаа нь гол төлөв 1-3 өдөрт бага цагт даалгаврыг сайн гүйцэтгэж байгаа нь тодорхой байна. ТБ-ийнхэн бие даалтад зарцуулах хугацаа 1.8%-аар багассан үзүүлэлт нь нэгдмэл байдлаар, нэг сэдвээс ургуулан бусад хичээлийн агуулгатай холбон төлөвлөснөөр оюутны бүтээлч хандлагыг өдөөж хялбар гүйцэтгэхэд нөлөөлснийг харуулжээ.

Оюутан бие даалтын ажлыг чанартай сайн гүйцэтгэхэд эргэх холбоотой ажиллах шаардлага байнга тохиолддог. Багш бүр зөвлөгөө өгөх арга барилаа (хүснэгт 1) улирлын эхэнд нарийн төлөвлөн оюутнуудад сайтар тайлбарласан.

Хүснэгт 1

Оюутанд бие даалтын зөвлөгөө өгөх арга барил (Feedback mechanisms)

| № | Зөвлөгөө хэлбэр, авах чиглэл (Types of Feedback) | ТХЦДХ | ЦСХБАЗ | ХХЭМ |
|----|--|---|--|---|
| 1. | Аман зөвлөгөө (тухайн гүйцэтгэх даалтын удирдамжийг оюутнуудад танилцуулах, зүйн боловсруулалт, сэдэв сонгох, хоорондын холбоог нэгтгэх) | <ul style="list-style-type: none"> • Тоглох дууны сонголт • Дуунд анализ хийсэн байдал • Аккордын бүтэн барилт • Аккордын холбоос • Дуулж хөгжимдөх байдал | <ul style="list-style-type: none"> • Удирдамжтай танилцах • Зурагт үзүүлэн • Биет үзүүлэн | <ul style="list-style-type: none"> • Сонгосон дууны хэмнэлд тохирох хөдөлгөөн • Бэлтгэсэн хэрэглэгдэхүүн ашиглах техник |
| 2. | Биечлэн үзүүлэх зөвлөгөө өгөх | <ul style="list-style-type: none"> • Дуулаад хөгжимдөх байдал • Дууны дахилт, амьсгалаа зохицуулах • Дууны утгыг илэрхийлэх байдал | <ul style="list-style-type: none"> • Хэрэглэгдэхүүний материал сонголт | <ul style="list-style-type: none"> • Дасгал гүйцэтгэх байдал • Хөгжим хөдөлгөөний тохироо • Илэрхийлэх байдал |
| 3. | Бэлтгэсэн хэрэглэгдэхүүн зөвлөгөө өгөх | | <ul style="list-style-type: none"> • Хүүхдийн хөгжилд тохирсон байдал • Өнгө • Гүйцэтгэл | <ul style="list-style-type: none"> • Хэрэглэгдэхүүний техник гүйцэтгэл |

Хичээл тус бүрээр зөвлөн туслах арга хэлбэрийг тусгахаас гадна цагийн хуваарийн дагуу ажиллаж тэмдэглэл хөгөлснийг тоон утгаар үзүүлсэн (график 4).

График 4

Оюутан багштайгаа эргэх холбоотой ажилласан үр дүн



Багшаас зөвлөгөөг 3-4 удаа авч эргэх холбоотой ажилласан байдал нь ТБ-ийн оюутнууд 26.3%, ХБ 33.3% үзүүлэлттэй байна. Харин 1-2 удаад багштайгаа эргэх холбоотойгоор ТБ нь 73.7%, ХБ 66.7% үзүүлэлттэй байлаа. Үүнийг дүгнэхэд оюутан төлөвлөгөөний дагуу даалгаврын мөн чанарыг ойлгож, өөрийгөө чадваржуулан хөгжүүлэх явцад гарч байгаа алдаа оноогоо дор бүрд нь хянаж, засан сайжруулснаар тэдний үнэлгээнд эерэг үр дүн үзүүлсэн байна.

Фокус бүлгийн ярилцлагын үр дүнд оюутны дэвшүүлж буй санаа бодол:

“Оюутан мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэхэд бие даалтын ажлын ач холбогдол” сэдвийн хүрээнд санал асуулга өрнүүлэхэд, оюутан өөрийн давуу талыг ашиглан даалгаврыг гүйцэтгэх, санаачилгатай байхаас гадна цаг хугацааг хэмнэх, багшлах ур чадварын туршлага хуримтлуулах боломжтой байна гэж санал нэгтэй байлаа. Оюутан Б.Г нь улирлын эхэнд бие даалтын ажлыг нэгдсэн нэг удирдамжаар гүйцэтгэх ёстой байсныг ойлгоогүй учир ажлаа эртнээс төлөвлөн цэгцтэй гүйцэтгэж чадаагүй ч богино хугацаанд засан сайжруулахад хялбар байсан. Харин оюутан Ц.Д нь нэг хичээлийн даалгаврыг нөгөө хичээлд хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байгаа нь сонирхолтой, цаг хугацааг хэмнэж чадсан гэв.

Хяналтын бүлгийн оюутны хувьд бие даалтын ажлыг хичээл тус бүрээр гүйцэтгэхдээ арга барилаа удаан хугацаанд эрэл хайгуул хийх, сэдвийн сонголтод эргэлзэх, бэлтгэл ажлаа хангахад цаг хугацаа алдсан. Оюутан өөрийн давуу чадвараа ашиглан нэг хичээл дээр сайн үнэлгээ авсан боловч бусад хичээл дээр хангалттай үнэлгээг авч чадаагүй талаар дурдаж байсан. Цаашид бие даалтын ажлыг сайжруулахад сэдэв болон хувилбарыг чөлөөтэй сонгох, олон хувилбартай болгох, хэлбэрийг өөрчлөх, хугацааг уян хатан болгох, тухайн оюутны болон хамтран суралцагчдын үнэлгээг тусгах арга замыг хэрэгжүүлбэл үнэлгээ бодитой болно гэж үзэв.

Дүгнэлт

- Оюутан бие даалтыг нэг сэдвийн хүрээнд нэгдмэл байдлаар төлөвлөн зохион байгуулахад зарцуулсан өдрийг тооцвол ТБ оюутны 59.6% нь 1-3 өдөрт буюу ХБ-ээс 8.72%-иар цөөн өдөр зарцуулсан, харин цагаар тооцвол өдөрт 31-60 минутыг ТБ нь ХБ-ээс 1.8%-иар илүү гүйцэтгэж арга зүйн хичээлүүдийг хослуулан олон талаас бүтээлчээр сэтгэн гүйцэтгэх чадварт суралцсан.
- ТБ оюутнууд ХБ-ээс дунджаар 3.86%-иар өндөр үзүүлэлттэй үнэлэгдэж байгаа нь оюутан удирдамжийн дагуу дуу сонгох, хичээлийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, эдгээрийг ашиглан дасгал тоглоомыг зохиомжлон биечлэн гүйцэтгэсэнээр хичээл хоорондын уялдаа холбоо сайжирч цаг хугацаа хэмнэсэн.
- Оюутны ялгаатай байдлыг харгалзан бие даалтын ажлыг олон хувилбараас сонгох, онлайн хэлбэрийг ашиглах, эргэх холбоотой бүтээлч идэвхтэй ажиллах нь тэдний мэргэжлийн ур чадварт нөлөөлж буйг судлан багш бие даалтын ажлын удирдамжийг тогтмол сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Талархал

Тус судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд СӨБС-ийн IV дамжааны оюутнууд өөрсдөө санаачилга гарган идэвхтэй оролцсон явдалд талархал илэрхийлье.

Ном зүй

- Батхуяг, С. (2012). *Дээд боловсролын сургалтын уламжлалт арга барилын шинэчлэл*. Улаанбаатар: Содпресс.
- Бадарч, Д., Наранцэцэг, Я., Батхүрэл, Г., Эрдэнэбаатар, А., Байгалтөгс, С., Базарсад, Я., Пүрэвдагва, Х., & Ганбат, Цс. (2014). *Кредит систем*. Улаанбаатар: Импресс.

- Боловсрол соёл шинжлэх ухааны яам. (2012). *Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл*. Улаанбаатар: Содпресс ХХК. Төлбөргүй холбоос <https://www.legalinfo.mn/law/details/462>
- Ичинхорлоо, Ш. (2011). *Дээд сургуулийн сургалт*. Улаанбаатар: Хөх Монгол принтинг
- Монгол Улсын Сургуулийн Өмнөх Боловсрол. (2019). *Дүрэм журам, гэрээ, маягтууд*. Улаанбаатар
- Henderson, M., Ajjawi, R., Boud, D., & Molloy, E. (Eds). (2019). *The Impact of Feedback in Higher Education*. Australia. <https://www.springer.com/gp/book/9783030251116>

Quality and Results of Summative Assignments in Optional Courses

Unenbayar Davaajav¹, Tuya Legden^{2*}, Erdenejargal Tseren³, Ariunzul Ulzii⁴
^{1,2} Methodical department, ^{3,4} Art department, School of Preschool Education, Mongolian National University of Education, Ulaanbaatar, MONGOLIA
*Corresponding author: ayut_1@msue.edu.mn

Received: 10/27/2020/

Revised: 5/11/2021

Accepted: 6/13/2021

Abstract

Students majoring in “Teacher and Preschool Education” complete independent assignments in accordance with the requirements and standards of the bachelor's degree program in higher education, general foundation, teacher education, compulsory and elective courses. Students' independent assignment is a process of learning, research, and creation that takes place outside of school hours under the indirect guidance of a teacher, based on their needs, interests, abilities, and future professional needs (Ichinkhorloo, 2015). Therefore, we aim to study the changes that will take place in the time spent on the integrated organization of independent assignments for Piano and Electric Music, Children's Movement Health, and the Kindergarten Teaching Material Development courses related to the professional methodology. The survey was conducted among fourth-year students and was based on a survey of the time spent on the assignment and the feedback from the teachers. The focus group discussions covered the issue of the significance of integrating assignments for professional courses. The average grade for the assignment for the three courses increased by 3.86% due to the fact that the interdisciplinary interrelationships were fairly close, thus easy to complete. Students completed independent assignments based on their strengths, enjoyed higher grades in other subjects, and were able to plan their time carefully and work productively in less time, improving the quality of assignments.

Keywords

Optional courses, integrated study, student creativity
